

ПРОФЕССОР Ц.ДОРЖИЙН АМЬДРАЛ БҮТЭЭЛЭЭС*

Х. Гаадан

(1965 оны 12 сарын 27-нд профессор Ц. Доржийн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр тависан илтгэл)

Эрдэм сурах хүсэл нь ундарсан хүн олныг номоор тэтгэх ариун үйлсэд нас биеэ зориулсан мэргэн багш Ц. Дорж 80 намрыг энх тунх өнгөрүүлээд та бидний дунд сууж байна.

Дорж багш 1885 оны сүүлчээр малчин ард Цэвэгийн гэрт төржээ. 20 нас хүртэл эцэг эхийнхээ гар дээр мал маллаж байгаад тэр цагийн эрхийг дагасан эцэг эхийн үгэнд орж хүрээнд сууж, төвд ном заалгаж эхэлсэн байна. Залуу насандаа заалгасан төвд номыг сүсэг бишрэлийн үүднээс цээжилсэнгүй, жинхэнэ учры нь ухаарч, юу байгаагий нь мэдэхээр махран оролдож нэрийн ном¹д мэргэжээд, тэр цагийн боловсрол олжээ. Хэдхэн жилийн дараа чойр, гүн ухаанд суралцаад түүндээ мэргэжсэний гэрч баримт болох « гавж » цол авсан байна. Гавж гэдэг бол энэтхэг төвдийн бичиг зохиолд гардаг 5 их ухаан, 5 бага ухаан, бүгд 10 ухаанд онц мэргэжсэн хүнд олгодог цол бөгөөд « 10 бэрхийг мэдэгч» гэсэн утгатай үг билээ.

1928 онд хүрээнээс гарч нийгэмдээ ашиг тустай хөдөлмөрт зүтгэж, Энэтхэг, Төвдөөс дамжин ирсэн элдэв төрлийн ном зохиолыг ажиглан шинжиж, хэрэгтэй хэрэггүйг ялгаж судалснаас гадна, ном зохиолоо төвд хэлээр бичсэн монгол зохиолчдын бүтээлээс судлах ажилд оржээ. Ийм учраас Дорж багшийг хуучин бичиг зохиолыг шинэ зорилт тавьж, шинэ үзэл санааны үүднээс судалсан анхны хүний нэг гэж хэлж болно.

Дорж багш төвд хэлээр байгаа бичиг зохиолын дотроос Монголын түүх, уран зохиолын судлал, шашны гүн ухааны зарим талыг судлахад холбогдох зүйлүүд дээр гол төлөв ажилласан хүн юм. Энэ чиглэлээр багшийн хийсэн ажлыг дурдахын өмнө төвд хэлээр буй бичиг зохиолын зүйлс дорно дахины судлалд ямар учир холбогдолтой болохыг товч дурдаж болох юм.

Дэлхий дахины шинжлэх ухаан, дорно дахины судлалд үлэмж анхаарал тавьдгийг бид мэдэж байна. Дорно дахины судлалын дотор эртний Энэтхэгийн гүн ухаан болон соёл шинжлэх ухааны бусад салбарууд, шашны чиглэлийн бичиг зохиолууд эрдэмтэн мэргэдийн анхаарлыг үлэмж татдаг юм.

Олон улсын эрдэмтдийн дотроос Оросын эрдэмтэн В. И. Васильев, Зөвлөлтийн

* Монгол Улсын Их Сургууль, Эрдэм Шинжилгээний Бичиг, 1969 он, №26.

¹⁾ урьд цагт төвд ном мэддэг хүмүүсийг уншлагатай хүн, чойрч хүн, нэрийн номд сайн хүн гэж хуваан үзэж байжээ. Нэрийн номд сайн хүн гэж орчуулж чаддаг хүнийг хэлдэг байжээ.

эрдэмтэн Ф. И Щербатский, А. И. Востриков, Унгарын Чома Де Кереш, Энэтхэгийн эрдэмтэн Сараад Чандар Даас, Германы Ф. У. Франке зэрэг олон хүн Энэтхэг төвдийн энэ бичиг зохиолыг ямар нэг хэмжээгээр судалж, шинжлэх ухаанд үлэмжхэн хувь оруулсан бөгөөд мөн цааш нь сонирхон судлах явдал үргэлжилсээр байна.

Энэтхэгийн эртний гүн ухаан, урлах ухаан, дуун ухаан буюу хэл зохиолын ухаан, анагаах ухаан, зурхайн ухааны талаар бичиж түүнийг янз бүрийн үзэл ойлголтын үүднээс тайлбарласан бичиг зохиол манай улсад үлэмж хэмжээгээр хадгалагдаж байгаа бөгөөд марксист-ленинист үзэл онолын үүднээс тэдгээрийг нарийвчлан судалсаар байна. Төвд хэлээр байгаа бичиг зохиолын материалыг судлах нь зөвхөн төвдөөр барахгүй төвдтэй холбоотой байсан Азийн бусад ард түмний түүх, соёлыг судлахад бас хэрэгтэй юм. Ялангуяа энэтхэг, монгол, хотон, хятадын түүхийг судлахад чухал хэрэгтэй гэж эрдэмтэд үздэг. Төвд орон шашин шүтлэгийн талаар нөлөөтэй болсноос хойш түүний ном бичгүүд зэргэлдээ орнуудад ихээхэн дэлгэрчээ. Сүүлийн гурван зуугаад жилийн турш Монгол, Тангад, Тува, Буриад зэрэг улс үндэстний дотор төвдийн утга зохиолын хэл нь дундад зууны европод латин хэл ямар шүү чухал болж байсны нэг адил чухал нөлөө холбогдолтой хэл болсон байна. Энэ үед монгол оронд төвд хэлийг хэрхэн эрхэмлэн үзэж байсныг Б. Я. Владимирцов тэмдэглэн хэлсэн байдаг. Төвд хэл 18-19-р зууны үед монголын утга зохиолын хоёр дахь хэл болж байв. Монгол дахь шашны сүм хийдийнхэн төвд хэлийг махран суралцаж, тэр хэлээр бичиж, шашин мөргөлийн ёслолыг үйлдэж байснаар барахгүй, хар феодалууд ч гэсэн төвд хэлэнд анхаарлаа тавьж, монголын ван түшмэдүүд боловсролтой болохыг эрхэмлэхдээ төвд хэлийг судалж байсан байна. Ингэхлээр төвд хэлээр янз бүрийн зохиол бүтээлүүд гаргахад бас бусад улс орон түүний дотор монголчууд оролцож, өөр өөрсдийн орны түүх, утга зохиол, бусад бичиг зохиолын зүйлийг бүтээж байсан нь тодорхой байна.

Монгол судлагчдын зохиолуудад шашин шүтлэгийн үзэл бүхий ном бичгүүд байгаагаас гадна түүхийн баримт мэдээ, гүн ухааны өвөрмөц сэтгэлгээ, хэл бичиг, уран зохиол, түүний судлалд холбогдолтой зүйлүүд их байдаг юм. Гэвч янз бүрийн үзэл, боловсролтой хүмүүс түүхийн өөр өөр нөхцөлд бүтээсэн хуучин цагийн бичиг зохиолын санг нийт ард түмний хүртээл болж, социалист эх орны хөгжил цэцэглэлтэд нөлөөтэй хүч болон үйлчилж байгаа манай өнөө үеийн хувсгалт соёлоос илүүд үнэлэн үзэж болохгүй гэдгийг бид үргэлж санаж байдаг билээ.

Эдгээр зохиолыг дан ганц эрдэм шинжилгээний зорилго тавьж судлах нь түүхэн үеийн элдэв агуулгатай бодол сэтгэлгээний үүсэл хөгжил, ард түмний хүсэл мөрөөдлийг шингээн тусгасан зохиол бүтээлүүд, тэдгээрийг харгис анги хэрхэн ашигласныг болон, шашин шүтлэг дэлгэрсэн нөхцөл ард түмний үзэл суртлын тэмцлийн түүхийг зөв ойлгож, жинхэнэ ёсоор дүгнэхэл ихээхэн хувь нэмэр болох юм.

Зөвлөлтийн эрдэмтэн Ю. Н. Рерих Монгол, Төвд хоёр орны харилцааны түүхийн талаар холбогдох бичиг зохиолын тухай хэлэхдээ «...Эдгээр нь үлэмжхэн байгаа боловч олонхий нь хэрэглэж болохгүй байгаа нь харамсалтай байна»² гэж бичсэн байдаг.

Профессор Ц. Дорж 80 хүртэл наслахдаа дээр дурдсан эрдэм шинжилгээний зорилтыг биелүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулсан хүн юм. Багшийн туулж өнгөрүүлсэн амьдралын замыг бид мэдэж байна. Нэг хэсэг үе нь бидний түүх шастараас уншиж мэддэг хаан төр, гадаад орны эзэрхийллийн үе, хүлцэнгүйн ёсны тангараг цааз болон, дөрвөн үнэний номын ухаан, судар тарнын аймгийн бясалгалыг бишрэн дагасан үе

² Филология и история монгольских народов, ст. 333

байлаа. Нөгөө нэг хэсэг үе нь Монгол оронд хувьсгал ялж, аз жаргалын гэрэлт замаар урагш давшин, марксист-ленинист тэргүүний шинжлэх ухаанаар үзэл онолоо гийгүүлж эх орондоо социализмийг төгс байгуулах үйлсэд хүчин зүтгэж яваа үе болно. Ийм их эргэлтийн үеийг амсан туулж өнгөрүүлэхдээ Дорж багш зөвхөн гэрчлэгчийн төдий явсангүй. Хоёр ёсыг эргэцүүлэн шинжиж, амьдралын үнэнийг ойлгоод шашингүйн үзлийн замыг сонгон аваад, улс эх оронд 40 шахам жил тасралтгүй үр бүтээлтэй хөдөлмөр хийсэн намын үзэл бодлыг хүлээн зөвшөөрч намд 30 гаруй жил болсон манай ахмад үеийн зүтгэлтэн хүн.

Бадам цэцэг ус, шавар дундаас ургасан байтлаа хир тоосыг нь өөртөө халдаалгүй шүүж ариун тунгалаг дэлбээгээ эрхэмсгээр дэлгэж бүхнийг баясгадаг билээ. Энэ бол бадам цэцэгт бохирыг шүүн тунгааж чадах сайхан чанар байснаас тэр бизээ.

Дорж багшийн уншиж судалж явсан номын дотор 6 зүйл хамаг амьтны тусын тулд маань уншихаас эхлээд гурван эрдэнэд итгэл өргөх, тахил өглөг үйлдэх, савдаг сахиус тахиж даллах, дой дордог үйлдэх, буг чөтгөр дарах зэргийн сүсэг бишрэлийн олон зүйл хоосон сургаал гардаг боловч түүнийг шүүрдэн хаяад мэргэдийн оюуны чадлын цогц болсон номын хуудсыг эргүүлэн цэнгэсээр одоо хүрэхдээ сайн үрий нь түүж. шимтэй хөрсөнд тарьж явсан хүн юм.

1928 онд хүрээнээс гарч харын дансанд ороод тэр үеийн судар бичгийн хүрээлэнгийн төвд номын тасагт номын санчаар орж ажилласнаас хойш хийж бүтээсэн зүйлийн зарим онцлогоос одоо дурдья.

Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байх хугацаандаа Монголын судлалд холбогдолтой элдэв ховор ном судруудыг салбар салбараар нь ангилан ялгаж, дутуу хагасыг энд тэндээс сурвалжлан олж нөхөх, бүх номыг нэр данстай болгох зэргээр ажиллаж, судалгааны материал бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ.

Мөн энэ үед чухал ховор зарим номыг орчуулдаг байсан байна.

Шашны гүн ухаанд томхон суурь эзэлдэг *«Дүнтэй»* буюу *«Тогтсон таалал»* гэдэг номыг монгол хэлээр орчуулсан нь одоо хүртэл гар бичмэлээр хадгалагдаж байна. Энэ ном нь ламын шашны *«Би үгүйн үзэл»*, *«Хоосон чанарын үзэл»* зэрэг 4 зүйл ухаан гэгчийн хуурамч мөн чанар болон шашны номлол дотроо үлэмж их зөрчилтэйг ухан ойлгоход тус болох материалыг агуулсан байдаг.

Дорж багш гүн ухааны номыг орчуулаад зогсоогүй бас түүхийн ном орчуулсан хүн. Номын санд байхдаа монгол зохиолч Зава Дамдины зохиосон *«Хор Чойнжин»* буюу *«Монголын түүх»* гэдэг номыг орчуулж, түүхчдээс уг номыг эх хэлээр нь унших бололцоо олгосон нь шинжилгээний ажилд багагүй тус нэмэр болж байгаа нь илэрхий. *«17-19 зууны үед гарч байсан түүхийн гол тэмдэглэл буюу чойжингууд нь сурвалж бичгийн хувьд ихээхэн ач холбогдолтой боловч шүүмжлэлтэй хандах нь зүйтэй»* гэж

Ю. Н. Рерих бичсэн билээ. Зөвлөлтийн эрдэмтэн Ю. Н Рерих тэдгээр түүхүүдийг ингэж чухалчилснаас гадна, дорно Төвдийн Дэргээ хотод хэвлэгдсэн *«Сажаа Гамбум»* гэдэг нэртэй 15 боть түүхийн ном, *«Содномдагва Жалцан»* тэмдэглэл, 1346 онд Жалан Гунгаадоржийн эмхтгэсэн *«Улаан дэвтэр»* нэрт сонирхолтой тэмдэглэлүүдийг түүхийн холбогдолтой зүйлүүд гэж ихэд үнэлж үзсэн байна.

Дорж багшийн орчуулсан *“Монголын түүх”* гэдэг номонд Монгол оронд шашин дэлгэрсэн тухай гол төлөв гардаг боловч түүнтэй холбогдож монголын онцлог байдал харагддаг сонирхолтой нэгэн түүх мөн.

Эртний Энэтхэгээс уламжлалтай 5 ухааны нэг нь анагаан сэргээх ухаан юм. Дорж багш анагаах ухааны ном судалж, эмийн ургамлын нэрсийг жагсааж, учир утгыг

тайлбарласан зураг сэлт бүхий нэгэн номоос чухал эмчилгээний холбогдолтойг түүвэрлэн монгол хэлэнд орчуулсан нь хойч үеийн хүмүүс цааш нь улам гүнзгийрүүлэн судлахад тус болж зохих хэмжээгээр ашиглагдах нь гарцаагүй. Бас төвд эмнэлэгийн хануур төөнүүрийн холбогдолтой 8 зургийг томруулан зурж төвд нэрийг монгол болгожээ.

Олон улсын анагаах ухааны судлал 5-7 зууны үед Энэтхэгээс Төвдөд нэвтэрсэн, энэ эртний уламжлалтай эмчилгээний аргад анхаарал тавин судалж зарим зүйлий нь хэвлэлдээ нийтэлснийг үзвэл камфар буюу гавар зэрэг ургамлын уусмал, стрихинин, бугын эврийн уусмал өгч эмчлэх, барьж илэх, усанд оруулах, цус авах, төөнөх аргуудыг тустай гэж үзсэн тухайгаа тэмдэглэсэн байдаг. Дорж багшийн эмнэлэгийн ном уншиж хийсэн эдгээр бүтээл нь орчин үеийн боловсролтой залуу эмч нарт ардын эмнэлэг, энэтхэг төвдийн гаралтай эмнэлэгийн зарим тустай талыг шинжлэх ухааны үүднээс судалж ажиглалт сорилт хийхэд нь ихээхэн үнэтэй гарын авлага болж өгнө.

Эдгээр орчуулгуудыг үзэхэд «*Мэргэд гаргахын орон*» гэдэг толь бичигт тогтоосон бөгөөд хуучин бичиг зохиолд нэгэнтээ хэрэглэсээр ирсэн нэр томъёог баримтлан, утгыг яруу сайхан холбон гаргаж, ойлгомжтой энгийн орчуулсан нь манай багшийн орчуулах авьяас, бүтээлч чанарыг харуулсан байна. Ер нь төвд хэлний ном зохиолуудад онжид буюу илт өгүүлэх нэр гэгчийг хэрэглэх нь их байдаг. Жишээ нь: ямар нэг муу үзлээс ангижрах гэхийг агуу хүчний эзэн, амгалан ажрагч, үл доройтогч гэх зэргээр нэрлэдэг, ийм далд утгатай ёгт нэрсийг жинхэнэ утгаар нь олж орчуулсан байна. Бас төвд хэлэнд ирээдүйг заасан үйл үгийг нэр үгээр бичдэг онцгой хэллэгийг монгол үйл үгийн жинхэнэ цагаар нь олж орчуулсан зэрэг найруулгын сайн талууд их байна.

Энэ хугацаанд Дорж багш монгол Данжуурын монгол гарчгийг түүсэн байна. Ганжуур, Данжуурын гарчиг бол самгарид, төвд, монгол гурван хэлээр бичигдсэн байдаг байна. Тэрхүү Данжуурын монгол гарчиг дээр самгарид, төвд нэрийг нэмж бас дээрээс нь Ганжуурын гарчгийг 3 хэлээр нь түүж нэмбэл маш том бүтээл болох бөгөөд энэ нь үлэмж хүч чармайлт шаардах юм.

Дэлхий дахины эрдэмтдийн сонирхон үздэг эртний энэтхэгийн 5 ухааны нэгэнд хуучин бичиг зохиолд, «*Дуун ухаан*» гэж нэрлэгдэж явдаг хэл бичиг, утга зохиолын ухаан ордог байна. Дээр үеийн судлагчид энэ талаар ихэд анхаарч байсан байна.

Дуу ухааныг судлан мэргэжиж улмаар оролдож бүтээх хүсэлтэй хүмүүст тус болохоор бүтээсэн зүйл манай багшид бас үлэмжхэн бий.

Монгол Улсын Их Сургууль гадаадын дээд сургуулиудтай харилцах явдал улам өргөжиж, тус сургуульд янз бүрийн шинжлэх ухааны салбарууд нэмэгдэн, судалгаа шинжилгээний ажилд олон хэл мэдэх шаардлагатай болж ирсэн үед проф. Дорж манай их сургуульд багшаар шилжин ирж ажиллажээ. 1959 оноос хойш одоо хүртэл тус сургуульд багшаар ажиллахдаа эрдэм шинжилгээний зорилгоор төвд хэл суралцах хүсэлтэй хүмүүст хэл зааж, төвд хэлний судлалын бүрэн курс сонсгон, зохих ёсны мэргэжил олгов. Түүнчлэн эрдэм шинжилгээний ажилд дур сонирхол бүхий авьяас, оролдлоготой хүмүүст зориулан төвд хэлний сурах бичгийг зохиосон билээ. Эдгээр сурах бичгийг зохиохдоо Гарамсэд, Сэрдэг, Агваандандар зэрэг хуучин нэрд гарсан судлагч нарын зохиолыг үзэж, жишиж харьцуулан, аливаа чухлыг авч байж зохиосон учраас төвд хэл сурахад хэрэгтэй, хамгийн боломжтой бүхнийг уг гурван боть сурах бичигт багтаан оруулсан гэж болно. Эрдэмтэн Ю. Н Рерих төвд бичиг үет үсгээр бүрэлдэж, тэр үет үсэг нь үгийн аймгийн аль ч хэсэгт орж явдаг учраас бусад хэлний адил төвд хэлийг хэлзүйн талаар хэлбэржүүлэхэд хэцүү хэл юм гэж тэмдэглэсэн байдаг

юм билээ. Дорж багшийн зохиосон сурах бичиг авианзүй, үгсийн аймгийг бас нилээд цэгцэлж, хуучин зохиолуудаас урагш алхсан сурах бичиг болсон юм. Энэ сурах бичгийн тухай профессор Ц. Дамдинсүрэн *«...төвд хэлний сурах бичиг ховор бөгөөд ялангуяа сургах шинэ аргаар бичсэн сурах бичиг байхгүй...»* гэж тэмдэглээд уг сурах бичгийг үнэлэхдээ *«Энэ ном бол төвд хэл сая заалгаж байгаа хүмүүст гарын авлага болохоос гадна, төвд хэлийг биеэ дааж гэрээр суралцахыг хүсэх хүмүүст чухал удирдамж болно»* гэсэн байна. Багшийн зохиосон энэ сурах бичгийг гадаадын төвдөч эрдэмтэд танилцаад зохих сэтгэгдлээ бичсэнийг бид олж үзсэн юм. Унгарын эрдэмтэн доктор Урай Гис энэ сурах бичгийг зохиохдоо төвдийн мэргэн багш Томи Самбода хийгээд Шон лозва Чойжинсамбуу тэргүүтнийг дагасан байна гэж дурджээ. Мөн уг сурах бичгийг төвдийн судалгаанд оруулсан чухал хувь нэмэр гэж Чехийн эрдэмтэн профессор Седлачек бас үнэлсэн билээ.

Буриадын эрдэмтэн Лувсанринчиний зохиосон толь бичиг гэж байдаг. Энэ толь бичиг төрөл бүрийн ухааны үг бүхий бөгөөд эрдэмтэн мэргэдийн анхаарлыг татсан бүтээл юм. Уг толь бичиг саяхан хүртэл гар бичмэлээр хадгалагдан өргөн дэлгэр ашиглагдахгүй, судалгааны хүмүүст үлэмж бэрхшээл учруулж байсан билээ.

Монголч эрдэмтдийн анхдугаар их хурлын үед энэ толийг дахин редакторлож нийтлэх бэлтгэл ажилд Дорж багш биечлэн оролцож, байхгүй зарим үгийг нөхөж уг толийг гаргалцсан нь их чухал зүйл боллоо.

1959 онд олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал Улаанбаатарт болсон билээ. Тус их хурал дээр Дорж багш төвд-монгол толь бичгийн тухай эрдэм шинжилгээний илтгэл тавьж, хэл судлалын энэ чухал зүйлийн талаар манай судлагчид хэрхэн ажиллаж ирснийг дэлхийн эрдэмтэд танилцуулсан юм. Зөвлөлтийн монголч эрдэмтэн С.А. Козин, Чойжи-Одсэрийн орчуулсан Бодизаръя Авадаараагийн тухай хэлэхдээ *«Тэр өгүүлийн утга уянгын эрхэм сайхан зүйлийг монголоор маш яруу найруулан хөрвүүлж, тэр үед хэл бичиг, анагаах ухаан, гүн ухаан зэрэг шалгадаг нарийн ухаантай болж, хэлний нэр томъёо цэгцэрч боловсон»* гэж тэмдэглэсэн байдаг. Тэр үеэс хойш монголчууд гадаадын соёлтой танилцаж, ном зохиолыг орчуулж эхлээд уг асуудал улам нарийссан байсан. Ингээд монголд элдэв төрлийн ухааны номыг орчуулж, уншигч нарт танилцуулах нэр томъёог багтаасан толь бичгүүд хожим олноор гарчээ.

Монголч эрдэмтдийн анхдугаар их хурал дээр тавьсан илтгэлдээ Дорж багш Бров Ранжамбын зохиосон *«Нэрийн далай»* *«Хурц оюун билэгтний үзэх нэгэн зүйл»* *«Нэр үг»* *«Утга бүхнийг багтаасан ёсон»*, үзэмчин Гомбожавын зохиосон *«Төвд хэлийг сурахад хялбар болгож гурвантаа шүүж зассан толь»*, Ролбидорж тэргүүтэй хэсэг зохиогчийн хийсэн *«Мэргэд гарахын орон»*, Агваан Дандарын зохиосон *«Харанхуйг гийгүүлэгч сарны гэрэл»* зэрэг 10 гаруй нэр төрлийн толь бичгийг дурдан гаргаж тайлбар сэлтийг хийж учир холбогдлыг нь өгүүлсэн байна.

Манай багшийн шавь Ч. Жүгдэр, Н. Жамбалсүрэн, Д. Цагаан нар эрдэм бүтээлийн ажилд үлэмж амжилт гаргасан байна. Мөн Дорж багшаар төвд хэл заалгаж ном ашигладаг болсон залуу эмч Хайдав Монгол орны эмийн зарим ургамалд судалгаа хийж, ургамлын хуучин нэр ба латин нэрийг түүвэрлэн, шинжлэх ухааны эмнэлгэд ихэд үнэлэгдсэн бөгөөд эмчилгээний чухал ач холбогдолтой, их нөөц бүхий 40 гаруй ургамлын тодорхойлолт гаргаж, тэдгээрийн жор найрлага дээр ажиглалт хийж, нилээд амжилт олоод байна. Хайдав эрдэмтний зэрэг авч энэ чиглэлээр цааш ажилласаар байна.

Манай багшийн хийж явсан эрдэм шинжилгээний энэ их ажил болон багшлах ажлынх нь амжилтыг нам, улс өндөр үнэлж профессор цол хүртээсэн байна.

Бид профессор Ц. Доржийн 80 насны ойг тэмдэглэж эрдэм шинжилгээний ажилд түүний оруулсан хувь нэмрийг үнэлэхдээ ном эрдмийн мөр хөөж яваа та бидний өмнө тулгаран буй хариуцлагатай бөгөөд хүндтэй үүргийг санах ёстой. Манай орны ажилчин анги, хоршооллосон ард, хөдөлмөрийн сэхээтэн нийт хөдөлмөрчид МАХН-ынхаа зарчимч бөгөөд алсын хараатай бодлогыг хэрэгжүүлэн эх орны социализмын материал техникийн баазыг зузаатгах үйлст сайхан амжилт олсоор байна.

Энэ их өрнүүн амьдралын дунд амьдарч яваа бид бүхний эрхэм үүрэг бол эрдэм мэдлэгийг эзэмшиж, эх орны соёл шинжлэх ухааныг улам цэцэглүүлэн хөгжүүлэхэд хүчин зүтгэхийн тулд оюуныхаа илдийг хурц иртэй байлгах явдал мөн.

Эрдмийн нууцыг барьж буй бат ханан хэрмийг очир алмаасан зэвсгээрээ хага цохин нурааж цаанаас нь хүслийг хангагч эрдэнэ-эрдмийг нээн гаргаж эх орон даяар түгээн урсгаж цэцэглэн хөгжихийн хүсэл бүхнийг ундлан тэтгэх ариун даалгаврыг нам та бидэнд өгсөн.

Заалгасан эрдмийг тогтоон эзэмшиж, номын садан болж, шинэ шинэ мэдлэг олохын тулд эрэл хайгуул их хийх нь чухал байна.

«Ухаантан мэргэд хэдий эрдэмтэй боловч

Улам улам ном судрыг цуглуулъя юу

Урсах мөрөн бүгд уламжлан дамжсаар

Усны сан болсон их далайд цутгах адил»

гэж иргэний нэгэн яруу найрагч шүлэглэсэн байдгийг та нар олж үзсэн байхаа.

Эрдэм ухааныг сурна гэдэг багагүй бэрхшээлтэй боловч түүнээс шантралгүй ажиллаж, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхийн гол түлхүүр болсон орос хэлийг сайн эзэмших хэрэгтэй байна.

Нам засгаас хүлээлгэсэн энэ их найдварыг биелүүлэх бүх бололцоо бидэнд бүрэн хангагдсан байна.

Профессор Дорж хүнд ном эрдэм зааж сургахаас гадна уйгагүй ажиллагаа шаргуу зүтгэлээр үлгэрлэж, хүнийг ямагт урагш тэмүүлэх эрмэлзлэлтэй болгон хүмүүжүүлдэг билээ. Ийм учраас таны 80 насны ойг тэмдэглэж бид эрдэм шинжилгээний хурал хийхдээ танай үлгэр дууриалаар чармайн зүтгэж, ихийг бүтээх эрмэлзлэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Эрхэм хүндэт профессор багш Ц. Дорж та эрдэм мэдлэгийн зулаар шавь нараа гийгүүлж, номоор тэтгэх үйлсийнхээ төлөө улам урт удаан насалтугай, бүтээтүгэй!

SUMMARY

The great teacher Ts. Dorj, who is filled with an energetic desire to learn and who has dedicated his life to supporting others with his teachings, remains alive and well among us at the age of 80.

Dorj was born at the end of 1885, in the family of the herder Tseveg. He herded livestock with his parents until the age of 20, at which point he followed his parents' wishes and moved to Huree, where he began to learn Tibetan. Rather than simply memorizing Tibetan sutras as religious prayers, he attempted to appreciate the full meaning of these texts. This led to his being conferred the title of "gavj" (geshe) after several years in recognition of his scholarly achievement, identifying him as a master of the ten Buddhist sciences.

Академич Б.Ринчен, төвдөч профессор Ц.Дорж нар (50-аад оны үед)

